

## “Баясгалангийн гарах орон хэмээх оршив” судрын агуулга, мөн чанар, ач холбогдол

**Мянгаагийн Саранцэцэг, доктор (Ph.D)**

*МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхим*

*Улаанбаатар, Монгол Улс, [saraa.myunga@gmail.com](mailto:saraa.myunga@gmail.com); <https://orcid.org/0009-0009-6403-4983>*

**Алимаа, докторант**

*МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхим*

*Улаанбаатар, Монгол Улс,*

### Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-23

Published : 2024-12-20

### Түлхүүр үгс

*Цахар гэви*

*Лувсанчүлтэм,*

*“Баясгалангийн*

*гарах орон хэмээх*

*оршив” судар,*

*Гал тахих зан үйл*

**Хураангуй:** Даяаршин буй өнөөгийн нийгэмд өвөг дээдсээс уламжлан ирсэн мэдлэг ухаан, соёл, ёс заншил мартагдахад хүрч улмаар үндэсний өв уламжлал, сэтгэлгээний онцлог, арга ухааныг судлах нь зүй ёсны асуудал болж байна. Эртнээс нааш монголчууд “Гал тахих зан үйл”-ийг тодорхой ёс заншлын дагуу хийж ирсэн бөгөөд энэ сэтгэлгээ нь нийгэм, хүмүүний амьдралын зохицуулалт болж, дараагийн үедээ уламжлан ирсэн түүхтэй. Энэхүү өгүүлэлд Цахар гэвиш Лувсанчүлтэмийн зохиосон “Баясгалангийн гарах орон хэмээх оршив” судар дахь гал тахилгын зан үйл ёс заншилыг тодруулан түүний орчин үеийн ач холбогдлыг тодруулахыг зорилоо.

### Keywords

*Tsahar Gevshe*

*Luvsanchultem,*

*sutra, rituals and*

*significance,*

*Fire Worship*

## The essence and significance of the scripture “The Land of Joy”

**Sarantsetseg Myangaa (Ph.D)**

*Department of the Social Sciences, Mongolian State University of*

*Education, Ulaanbaatar, Mongolia, [saraa.myunga@gmail.com](mailto:saraa.myunga@gmail.com); <https://orcid.org/0009-0009-6403-4983>*

**Alimaa (Ph.D candidate student)**

*Department of the Social Sciences, Mongolian State University of*  
*Education, Ulaanbaatar, Mongolia*

**Abstract:** The issue of state-religious relations has recently attracted considerable attention. As religious freedom and non-religion become more and more common in society, it is necessary to improve the state’s religious policy. Here we will examine how the Mongolian Government has solved the following religious issues. It includes: 1. The nature and interaction of the concepts of state policy, religious issues, and philosophical approach; 2. How wise men define similarities and differences between state and religion; 3. State laws and religious missions, their independence and interdependence; 4. Religion is an integral part of society’s spiritual life;

© The Author(s), 2024



5.Religion and national consciousness; 6.Religion and social morality; 7.Religion and civil education; 8.State policy on religious issues. The State regulates social relations through state legislation, requires citizens to comply with state laws, and oversees their implementation, and religion increasingly plays

## **I. Оршил**

Хүн байгалийн харилцан шүтэлцээнд иргэншиж ирсэн монгол түмэн дэлхийн хүн төрөлхтөний дэвшлийн нэгэн адил байгалийн галыг нээн мэдэрч ашиглахын зэрэгцээ гал тахилгын өвөрмөц соёл, зан үйлийг бүтээсэн юм. Монголчуудын гал тахилгын зан үйлийн ёс заншил нь аймаг сум, бүс нутагт бага зэрэг ялгаатай байдаг боловч ерөнхий эрэмбэ дараа, нийтлэг тал, журамлах зүйлийг мөрдөн гаргаж болох юм.

Хэдийгээр угсаатан судлал, бөө судлаачид, түүхчид, шашны эрдэмтэн судлаачид гал тахих ёс, зан үйлийг судалсан хэдий ч түүнийг бие даасан тусгаар бус зөвхөн үйлдлийг судалсан байгаа нь түлхүү ажиглагддаг. Энэ талаар монгол ёс заншлын тайлбар толиуд, угсаатан судлалын судалгааны бүтээлүүд, ардын сурган хүмүүжүүлэх ухааны ном зохиолууд, ардын байгаль хамгаалах уламжлал, ардын мэдлэг ухааны уламжлалтай холбоотой шинжлэх ухааны бүтээл туурвил, ном зохиолууд хэдийгээр дагнасан биш боловч цөөнгүй байна. Ингэхдээ хавсрага юм уу, цухас дурдсан эсвэл тэмдэглэн үлдээснээс нэгтгэн нэг сэдэвт бүтээлийн хэмжээнд эмхэтгэн судалсан нь одоохондоо ховор байна.

Тухайлбал, Өвөрмонголын ардын хорооноос 1980 оны үед хэвлүүлсэн орон нутгуудын зан үйлийн тухай ном, Хорчны зан үйл, Баарны зан үйл, Альша зан үйл, Ордос зан үйл гэх мэт

ном зохиолд орон нутгийн тус тус зан үйлийн талаар дурдсан байдаг. Мөн Өвөрмонголын эрдэмтэн Алтанбагана, Ням, Сөөө нар өөр өөрсдийн бүтээлдээ монголчуудын галыг шүтэн дээдлэх, хэзээ, хэрхэн яаж, хэн тахидаг зэрэг талаас дурджээ. Монгол улсын эрдэмтэн Л.Отгонбат *«Монголчуудын идээ ундааны ёс уламжлал»* хэмээх номондоо гал тахилгын өргөл цацалд холбогдох шүүс идээний цээр ёсны талаар нилээд нарийн тодорхойлсон байна. М.Банди “Монгол ёс заншлын тайлбар толь”-д гал тахих, гал голомтоо дээдлэх ёс журмын талаар тайлбарлан бичжээ.

## **II. Үндсэн хэлэлцүүлэг**

Цахар Гэвш Лувсанчүлтэм бол XVIII-XIX зууны зааг үед амьдарч байсан гүн ухаантан, яруу найрагч, гарамгай орчуулагч, шашны нэрт зүтгэлтэн. Тэрээр XII жарны төмөр бичин жил буюу 1740 оны 8-р сарын 3-ны өдөр Цахарын Хөвөөт цагаан хошууны Сайхан хэмээх нуурын баруун хөвөөнөө Уйгад овгийн эгэл ард Цэгэнжал, Халзанхүүгийн ууган хөвгүүн болон мэндэлжээ. Лувсанчүлтэм 7 настайдаа авга ахаасаа монгол бичиг сурсан бөгөөд дараа нь төвд төв үсэг, таталаган бичиг сурч хурлын уншлага цээжилж эхэлсэн. Чайв хутагт эрдэнэ Лувсанпэрэнлэйгээс увш сахил ба Лувсанчүлтэм хэмээх сахилын алдар хүртсэн боловч нийтэд Цахар гэвш

гэдэг нэрээр алдаршин, өөрийн нутгийн хийд Бусдыг туслагч бодь тив (Шанпан жанчив лин хийд) нэртэй сүмийн хуралд хурдаг болсон байжээ. Тэрээр 15 настайдаа дорнод монголын шашны томоохон төв болсоор ирсэн Долоон нуурт заларч Ачит номун хаан Лувсанданзангаас гэцэл сахил хүртсэн байна. 16 насандаа Долоон нуурт ширээт хувилгаан Лувсандамбийням гэгээнийг багшаа болгон гэлэн санваар хүртсэн. 23 настайдаа Бээжин дэх Найралт найрамдуу сүмийн сургуульд сууж, зургаа долоон жил шахуу шашны гүн ухааныг судалж суралцан, судар номд мэргэшиж алдар нэрд манджээ.

Тэрээр насан туршдаа бурхны ном бясалган уншлага уншихын дагуу монгол төвдөөр их хэмжээний ном судар зохион гаргаж, орчуулан найруулсан байна. Үүнд: Энэтхэг, төвд, монголд шашин ном дэлгэрсэн түүх, бурхан шашны үүсэл хийгээд лам хуврагийн ёсон, сүм хийдийн дүрэм горим, гал тахих ёс жаяг, сүлд тэнгэрийн тахилга, насан хутгийн даллага авах ёсон, архи тамхины ятгал, зангидийн ном зэрэг олон зүйлийн ном судар зохион туурвижээ (Бира Ш. 1978, 43). Цахар гэвшийн намтар монгол, төвд хэлээр хэвлэгдсэн 200 гаруй боть ном бий. Үүнийг түүний шавь Лувсансамдунням зохиосон. Лувсансамдунням 1817 онд бичсэн “Гэтэлгэгч дээд лам адилтгал үгүй ачит богд Сумадиш бадрагийн гэгээний ерөнхий зохиолын намтарыг товчийн төдий өгүүлсэн сүсгийн лянхуаг мишээлгэгч нэрээр гэрэл дээд мөрийг гийгүүлэн үйлдэгч хэмээгдэх оршив” гэсэн төвд монгол хэлээр нийтлэгдсэн намтар зохиол ихээхэн ач

холбогдолтой (Цэрэнсодном Д. 1997, 125). Түүний намтар бүтээлийн талаар Ц.Дамдинсүрэн (1957, 1961, 1975), Ш.Бира (1978), В.Хайссиг (1995), Ч.Алтаргэрэл (1967), Л.Хүрэлбаатар (1995), Д.Цэрэнсодном (1987), Очи (1996) нарын судлаачид судлан нилээдгүй бүтээлүүдийг бичжээ.

Цахар гэвш буддын уран зохиолын олон чухал дурсгал бичгийг монгол хэлнээ яруу тансаг орчуулж дундад зууны үеийн монголын орчуулгын түүхэнд шинэчлэл хийснийг Ц.Дамдинсүрэн онцлон тэмдэглэж байв. Намтар цадиг, хүрээ нийд, ариун дагшин орны тухай бичиж туурвисан бүтээл, сүм дуган байгуулсан, номын бар хэвлэлийн газар буй болгосон, монгол хэлээр шашны номыг урин уншихад түүний оруулсан хувь нэмэр их. Иймийн тул Цахар гэвшийн шашин номын, монгол зан үйлийн талаар, түүний зохиосон “Галыг тахих зан үйл баясгалангийн гарах орон хэмээх оршив” (дорогш баясгалангийн гарах орон хэмээх оршив хэмээн товчилно) хэмээх судар нь тухайн цаг үедээ чухал нийгмийн ач холбогдолтой байснаар барахгүй, XXI зуунд түүний ахуйч үнэ цэнийг эрдэм шинжилгээний шинэ эргэлтэд оруулж, монголчуудын гал тахих ёс зан уламжлалыг мөрдөн шүүж, гал голомт тахих ёсны утга агуулгыг цаашид нягтлан судлахад ихээхэн ач тустай юм.

Ардын үлгэр домгийн өгүүлэмжийг өргөнөөр ашиглан “Гал тахих зан үйл баясгалан гарахын орон”, “Гүүний сүүний цацлын ёсон” гэх зэрэг шүлэг магтаалаараа шашны зан үйл, билэг чанарын зүйлийг ардын ахуй амьдралын бодит хэрэгцээ,

хэрэглээний соёлд ойртуулж өгсөн. Энэ чанараараа Цахар гэвшийн шүлэг, сургаал, магтаал, тайлбар тэргүүтэн олон зохиол нь зөвхөн сүм дуганы явцуу хүрээнд үлдсэнгүй, жирийн айл гэрт түгэн тархаж нийтийн хүртээл болж чадсан. Түүний нэг тод жишээ бол «Гал тахих зан үйл баясгалан гарахын орон» хэмээх судар юм.

XVII-XVIII зууны үед төвд хэл монголчуудын оюун санааны амьдралын нэг салаа мөчир болж улмаар монголчуудын жинхэнэ утга зохиолын хэл болж чадсан. Энэ үеийн монголын эрдэмтэн лам нар зохиол бүтээлээ төвд эсвэл төвд-монгол хоёр хэлээр бичиж монголын буддын соёл, утга зохиолын өв сан төвд хийгээд монгол хоёр бичгээр цогцолсон. Судлаач Л.Хүрэлбаатар монгол бичиг номын түүхнээ хоёр хийгээд олон хэлний хавсарсан орчуулга “дуун хөрвүүлэх ухаан” бичиж хөрвүүлж бүтээн туурвиснаа дэлгэрүүлэх ном судар болгон түгээх ухааныг хөгжүүлж хүмүүн нийтийн соёлын санд зохих хувь нэмрийг оруулсан (Хүрэлбаатар Л. 1997, 125) хэмээн дүгнэсэн. Дашрамд дурдахад: Үгчлэн орчуулах уламжлалт аргыг эвдэж утгачлан монгол хэлнээ яруу тансаг найруулгаар буулгах уламжлалыг сэргээн шинэ шатанд гаргасан хийгээд XVIII зууны монголын орчуулгад утгачлан орчуулах, дууриалган зохион орчуулах дэг маяг бүрэлдэн төлөвшихөд Цахар гэвш үнэтэй хувь нэмэр оруулсан юм (Философийн хүрээлэн, ШУА 2001) гэж онцлон дурдсан байдаг.

XVIII зууны монгол эрдэмтэн лам нарын бүтээн туурвисан бичгийн арвин өв сан бидэнд уламжлагдан

монголчуудын нийгмийн сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзлийг судлан боловсруулахад үнэтэй хувь нэмэр болж ирсэн. Түүний нэгэн тод жишээ бол Цахар гэвш Лувсанчүлтэмийн зохиосон «Баясгалангийн гарах орон хэмээх оршив» хэмээх судар болно. Уг бүтээлийг бичих үеийн монголын нийгэм улс төр, оюун санааны ертөнцөд нэг талаас дорно дахины соёл (энэтхэг, төвд) сэтгэлгээний ололт болсон бурханы шашин, нөгөө талаас Манж Чин гүрэн өөрийн эрхшээлийг бүрэн тогтоосон үе байсан. Хүннүгийн үеэс дэлгэрэн ирсэн буддын соёл нь зуун зуун дамжин хөгжиж ирэхдээ монгол ахуй, монголын соёл, монгол зан заншилд гүн нэвтэрч шинэ дүр төрхийг бүрдүүлж байв. Нүүдэллэн жилийн дөрвөн улиралд малаа даган аж төрж ирсэн монголын ард түмний соёлд дэвшилтэд нөлөө үзүүлснийг үгүйсгэх аргагүй.

Монголчуудын гал тахилгын ёс заншил нь монголчуудын уугаал шүтлэг болох бөө мөргөлийн соёлын хөрсөн дээр бүрэлдэж тогтворжсон байдаг. Энэ нь энгийн иргэдийн дунд бол аман яриа хэлбэрээр уламжлагдаж байсан юм. Бид бүхний мэддэгээр шарын шашин монгол оронд дэлгэрэн ноёрхох байрыг эзэлснээр бөө мөргөлийн агуулга бүхий гал тахилгын зан үйлд эрс ондоо өөрчлөлт гарч агуулга хэлбэр нь цоо шинээр хувираад, аман ярины дуудлагын хэлбэр нь бичгийн буюу дармал судрын хэлбэр шинжтэй хөгжих болсон. Улмаар лам нарын уншлагын хэв маяг үүсэж, гал тахих зан үйлийг хийхэд зөвхөн бөө нараар тахиулах бус, голчлон лам нараар тахиулдаг

болж хувирчээ. Ийнхүү нийгмийн хөгжлийн явц аяндаа үзэл ухамсрын хувьсалыг авчирсан түүхэн ахуй байдалд Цахар Гэвш Лувсанчүлтэм «Баясгалангийн гарах орон хэмээх оршив» хэмээх судраа зохиож, монголчуудын уламжлалт шашин болох бөө мөргөлийн гал тахилгын дуудлагын агуулгын суурин дээр, шар шашны судар номлолын агуулга бүхий гал тахилгын ёс жаягийг нэг ёсны эрэмбэ дараатай туурвиад, соёл иргэншлийн уламжлал ба өөрчлөлтөд үйлчлүүлсэн юм. Энэ талаар судлаач Сөөө Монголчууд орд гарцаар манжийн дарлалыг амсаж, нэн цоо шинэ бурхан шашны наадгай зүйлээр монголчуудыг шахаж мунхруулан, лам хувираг болгон үр үндсийг нь цөөрүүлж, хүч тамрыг нь бууруулж, номотгох арга бодлого авч байжээ. Иймд, монголчуудын дотор манжийн бодлогыг жигших, өөрийгөө аварч ухамсарлах нийгмийн сэтгэлгэний урсгал гүн нэвтэрч үүссэн юм. Энэ бүхэн Цахар Гэвш Лувсанчүлтэм «Баясгалангийн гарах орон хэмээх оршив» хэмээх судрын зохиогдсон түүхэн ахуй болно (Сөөө З. 2012, 1011-1017) гэж тэмдэглэсэн нь буй.

“Баясгалангийн гарах орон хэмээх оршив” хэмээх судрыг “Гал тахилга”-ын судар хэмээн монголчууд эрхэмлэн дээдлэж ирсэн. Энэхүү судар нь тайлбар, тодорхойлолт зэрэг үргэлжилсэн үгийн хэсгээс гадна, гал тахих зан үйлийн ёс жаяг, зан үйлийн эрэмбэ дарааг хоёр зуун дөчин зургаан мөр шүлэгт багтаан бичсэн бүтээл юм. Уг судрыг задлан шинжлэвэл доорхи байдлаар илэрхийлж болно.

*о Тайлбарлаж тодорхойлсон. Энэ хэсэгт голдуу гал тахилгын бэлтгэл буюу мах шүүс, идээн ундаа, архи сэржим жич сав хэрэгслийн ариун цэвэр, цээр хоригийн талаар тод томруун өгүүлжээ.*

*о Гал тахилгын эрэмбэ дараа ба явц. Энэ тахил өргөх ёс, тахилын зан үйлийн ёс, даллага авах ёс гэсэн 3 агуулгаас бүрдэнэ.*

“Баясгалангийн гарах орон хэмээх оршив” хэмээх судар ийнхүү гал тахилгын зан үйлийн явц, эрэмбэ дарааг тодруулан бичсэн байдгаараа онцлог юм.

Монголчуудын гал тахилгын үүслийн тодорхой цаг үеийг тогтооход хэдийгээр бэрх боловч, бөө мөргөлийн зан үйлтэй холбогдуулан судалдаг. Учир нь бөөгийн шүтлэгт тахилгын ёс голлох байр суурьтай бөгөөд монгол бөөгийн тахилгад голлон гүйцэтгэдэг ёслол бол тэнгэрийн шүтлэг, уул усны тахилга, овоо тахих, ханш тахих (бөөгийн шүтлэгээр сахиус оршсон гэх хээрийн ганц мод, хайлаас), ундрага тахих ёсыг дурдаж болно. Түүнчлэн галын тахилга, өвөг дээдсийн тахилга, ганзага тахилгын ёснууд байдаг (Давгадорж Д. 1995, 70). Бөөгийн тахилга бол байгаль ертөнцийг эзэн тэнгэртэй хэмээн итгэж, түүнтэй харилцах харилцааны зан үйл бөгөөд энэхүү зан үйл нь түүнийг аргадан өргөл мөргөл хийх замаар гүйцэтгэдэг зан үйл юм. Цахар гэвшийн зохиосон “Гал тахилга”-ын судар бөөгийн тахилгын нэг хэлбэр болж байна.

“Гал тахилга”-ын эхний хэсэгт (Оч Н. 2010, 278-279) гал тахих гэж буй хүн юуг хэрхэн бэлтгэсэн байх тухай тайлбарлах, тодруулах хэлбэрээр

бичсэн байдаг.

Гал тахих зан үйлийг хийхэд тодорхой дэг жаягийг баримтлан хийх нь тухайн өрх гэр, хувь хүн галын эзнийг хүндэтгэн нарийн ёс заншилаар үйлдэгддэг. Иймд тахилгад бэлтгэх нь энгийн мэт боловч оюун сэтгэлийн хувьд бишрэл хүндэтгэл бий болгодог. Монгол туургатан бүр эртнээс галыг хамгаас эрхэмлэн хүндэтгэж, нандигнан хамгаалж ирсэн бөгөөд өвгөд хөгшид “Галын бурхан” гэж гурван настай балчир хүүхэд байдаг гэлцдэг. Тахилгын ёсон бүхлээрээ хүн байгалийн харилцаанд хатуу дагаж мөрдөх амьдрал үйл ажиллагааны хэм хэмжээг өөртөө агуулсан байх бөгөөд тэр чигээрээ хорио цээрээр баялаг байдаг. Тухайлбал,

*Гал руу хог нови, сонгино сармисны хальс, муу юм хийдэггүй.*

*Галын бурхан бузартана гэж цээрлэдэг.*

*Шар тос, архи, өөх мах, шинэ торго дурдангийн өөдөс өргөдөг.* (Шагдарсүрэн Ц. 2003, 35)

*Гал тахилгын бэлтгэл ажил мах шүүс, идээн ундаа, архи сэржим жич сав хэрэгслийг ариун цэвэр байлгаж, цээр хориог хийсний дараа тахил өргөх шатанд орно.*

Тус сударын дараагийн шатанд гал тахилгын эрэмбэ дараа ба явцыг тахил өргөх ёс, тахилын зан үйлийн ёс, даллага авах ёс гэсэн дарааллын дагуу явагдахыг дурдсан байна. Тэдгээрийг тодруулбал,

### *1. Тахил өргөх ёс*

Тахил өргөх ёс нь шүтээний биет хэлбэр бөгөөд бие, сэтгэл, хэлээр мөргөл, өргөл үйлддэг зан үйлийн

ёсон юм. Түүхийн эх сурвалжийг эргэн харвал, Хүннүчүүд жил бүрийн хавар “өвөг дээдэс, тэнгэр газар, сүнсэнд” өргөл барьц өргөдөг байв (Гумилев Л.Н. 2000, 82). Тэгэхээр монголчууд эртнээс нааш тэнгэр газар усны эзэд, дээдсийн сүнс онгодод залбирах, өргөл өргөх зан үйлийг хийж иржээ. Зан үйл харьцангуй тогтвортой шинжтэй бөгөөд өмнөх үеэс хойч үедээ уламжлагддаг. Гэхдээ үеэ өнгөрөөсөн, хатуу чанд зан үйл нь цагийн аясаар орхигдон нийгмийн хөгжлийг даган шинэ агуулгаар баяжин хөгжиж байдаг жамтай. Бөөгийн шашны гал тахилгын ёс нь буддын шашин дэлгэрснээр хувьсан өөрчлөгдсөн. Эндээс харвал зан үйл нь дотоодын төдийгүй гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөн хувирдаг бөгөөд энэ нь ямар ч улс үндэстний заншил бусдаас салангид тусдаа бус харин өөр хоорондоо уусан холбогддог шинжтэй.

*... Айлдах энэрэнгүй эрдэм хотол дүүрээд*

*Амарлингуй догшин элдэв хувилгааныг үзүүлэгч*

*Асралт гал тэнгэр нөхөд зэргийг*

*Ариун тахил өргөхийн тул энд урин залмуй.* (Шонхор А., Цэцэнбилэг. 2017, 8)

Галыг ариун дагшин шүтээн болгож шүтдэг нь монголчуудын хамгийн эртний шашин суртахууны нэг ойлгогдохуун юм. Гал голомтоо ариун байлгаж, галаар ариутгах ёс монгол айл өрх бүрт тогтсон заншил юм. Гал тахилгын ёсонд айлын гал голомт эзэн тэнгэртэй гэж үзэх учир жил бүр галаа тахиж галын эзнийг хүндэтгэдэг. Гал тахилгын сударт



тахилга өргөлийн зүйл бэлтгэх ба адислахыг тодорхой заасан байдаг. Галын шүтээн болсон галын тэнгэр, галын хааныг урин дуудаж идээ тахил засаж, өргөл магтаал хайлж, ном судар уншуулж, өлзий хишиг гуйн ёсолдог дэгтэй. Юуны өмнө тахилын өргөл нь

- o *Гал галайхан эх буюу галын бурхан ба нөхөр сэлтийг урих;*
- o *Гал галайхан эх буюу галын бурхан ба нөхөр сэлтэд тахил өргөх зэргийг багтаадаг.*

Жишээлбэл, Галын бурхан ба нөхөр сэлтийг магтахдаа

*Амин насыг орд болгохын тулд*

*Эрхэм тэргүүтнийг амирлахын тулд*

*Үгүйрэхийн зовлоноос аврахын тулд*

*Үлэмж жаргаланд умбахын тулд*

*Хэдий бөх орчлонгийн хамаг амьтны*

*Хэзээд бүтээн зохиогч*

*Хэтэрхий гал тэнгэр нөхөд бусдыг магтамуй” (Шонхор А., Цэцэнбилэг. 2017) гэсэн байдаг.*

## 2. Тахилын зан үйлийн ёс

Энэхүү зан үйлийн ёс нь амьдрал, ажил үйлс цэцэглэн хөгжих, эд агуурс элбэг хангалуун, өвчин зовлонгүй эрүүл саруул байх, санасан сайн сайхан зүйлээ хүсэн даатгадаг. Жишээлбэл,

*“Эрх хүчин хотол олон гал тэнгэрийн чуулганаар*

*Өргөсөн эдгээр тахилыг баясан зооглоод*

*Ирж хүссэн ямбаар хэрэгтнийг хоцролгүй*

*Энэрэнгүй сэтгэл жор бүтээж хайрлан соёрх*

*Халуун хүйтэн хямарсан тэргүүтэн элдэв өвчин ба*

*Харшлан хор үйлдэгч өстөн дайсан ба*

*Хагалаагийн чөлөө эрэгч ад зэтгэр тэргүүтэн*

*Хамаг үл зохилдон нугагтыг амарлиулан соёрх*

*Аливаад зуд торхон хийгээд чоно хулгай ба*

*Адгуусны элдэв зүйл гамшиг үхэл тэргүүтэн*

*Адуу малд хор хоромж болох бүгдийг Амарлиулж устгахын үйлийг зохион соёрх*

*Амин насан орд болон цог зол бадраад*

*Адуу мал, эд идээ үлэмж дэлгэрч*

*Алдар нэр аугаа хүчин улам нэмэх тэргүүтэн*

*Аливаа сайн нутагтныг хотол төгссөөр соёрх*

*Аль орно суух ба аль зүг чигт явах хийгээд*

*Аливаад хатуу зөөлөн ямар үйлийг үйлдэвч*

*Авран ивээхээ өчүүхэн цоо суртал өгье*

*Аливаа хүссэн тусыг сайтар бүтээн соёрх” (Шонхор А., Цэцэнбилэг. 2017)*

гэх мэтээр даатгадаг байна.

## 3. Даллага авах ёс

Даллага нь туйлын зорилгод чиглэгдэн эрэмбэлэгдсэн хүсэл бөгөөд түүнийг ерөөл магтаал уншиж айлддаг. Ерөөл магтаал айлдах нь сайныг хүсэх, бурхад догшдыг магтсан шүлгээр аливаа хүслийг бүтээхэд зориулан уншина. Галын тахилгын сударт:

*Ачит язгуур үндсэнтэн багш нарын буян хийгээд*

*Аврал дээд гурван эрдэнийн*

*Аливаад сайн муу улам хомс болох ба Адаг муу улам элбэг болох*

*Асар доройтолд энэ цэвүүн цагийн*

*Аюул нутагтан бүхнээс авран соёрх*

*Аврал бурхны шашин өнөд дэлгэрээд*

*Амьтан тус амгалангийн цог дор настан цэнгэхийн*

*Асар сайны чуулганыг шинийн сар мэт*

*Арвижин дэлгэрэхийн үйлсийг зохион соёрх*

*Аугаа хүчин төгөлдөр сахиусийн буян лугаа*

*Аливаад сайн буян нутагтаныг энд ирүүлэн соёрх” (Шонхор А., Цэцэнбилэг. 2017)гэх мэтчилэн шүлэглэн даллага авч буян хишиг “Хурай, хурай, хурай” гэж хуралддаг байна.*

*... Эрхт богд лам нарын өлмий бататгаад*

*Эрдэнэ шашин ном арван зүг дор дэлгэрч*

*Эх болсон хамаг амьтан настан жаргахын*

*Эргэн сайн нутагт өнөд бадрах болтугай*

*Эрх хүчин төгөлдөр галын чуулганаар*

*Энэрч манай тусыг бүтээсэн маш ачтай болвой*

*Өдгөө өөрийн орондоо авчран залаад*

*Үүрд үлдэлгүй нигүүлсэхүйгээр айлдан соёрх. (Шонхор А., Цэцэнбилэг. 2017)*

Галын ерөөл уншиж буй тэр агшинд тал талд хэсэг ерөөл уншигч (лам хувраг) сумаа барьж, гэрийн эзэн даллаганы уугаа хадгийн дээр барьж хурайлан даллаж, галын тахилгад оролцон бусад хүмүүс малын өвчүү, хадаг, хөхүүр, тавагтай цагаан идээ, боов боорцог барьцгаан “хурай, хурай, хурай” гэж хурайлан далладаг. Судлаач Сөөө Даллага даллаж дууссаны дараа, даллагын уугаа хураан хадгаар бүтээн тавиж, гурван хоног нээдэггүй. Дөрөв дэхь өдөр нь галын хишиг гэж садан

төрөл, айл саахалтантай хуваалцан идэж, үлдсэнийг нь гал тахилгад оролцоогүй хүүхэд ач зээ нартаа хадгалан үлдээдэг ёс заншилтай байжээ (Сөөө 3. 2012) гэж галын хишгийг түгээдэг ёсны талаар дурдсан.

Цахар гэвш “Баясгалангийн гарах орон хэмээх оршив” хэмээх сударын төгсгөлд: Гал тахилгыг тахихдаа идээ ундаагаар баяр хурим үйлдвээс хишиг бадрахын эхлэл болно (Шонхор А., Цэцэнбилэг. 2017). Зарим гарын авлага зэргийг ихэнх ард иргэд мэддэг тул энд эс өгүүлэхүүн хэмээн гал тахихын зан үйлийг баясгалангийн гарах орон судрыг эрдэм төгс лам хувраг нараар номын ёсон хийгээд ордсын хуучин журам хоёул зэрэгт үл харшлах ёсон болгож найруулан бичсэн судар юм. Энэ судрын зарим бичвэрт:

*Үүрд сайн жаргалан хотол төгсөх болтугай гэжээ.*

Эндээс үзвэл “Баясгалангийн гарах орон хэмээх оршив” хэмээх сударт гал тахих өдөр сар, цаг хугацаа хийгээд тахилгад орох зүйлийн засаж янзлах талаар нарийн дэлгэрэнгүй дурдсангүй байна. Гэтэл монголчууд “Гал тахих билгийн улирлын хорин гуравны өглөө эртлэн босож, гэр тэргээ цэвэрлэж тоос тортоого гэвж, хүрээ хашаагаа шүүрдэж арц хүжээр ариутгадаг”. Түүнчлэн гал тахилгын хамгийн чухал зүйл болох “Өвчүү засахад гэрийн эзэн буюу гал тахих хүмүүн гараа сайхан ариутган угааж, хутгаараа өвчүүний бүдэрхийн үзүүрээс эхлэн махыг нь шулж, аюулхайн хэсгээс хоёр тийш яраад, хутганы үзүүрээр өвчүүний хормойгоо тойруулан авч, махыг нь салгахгүйгээр хуруу өргөн зүссээр



цоройн доод хэсэг рүү хормойгоор битүү гаргадаг” (Энх-Уянга Б. 2016) гэх мэтчилэн зан үйлийг хийж гүйцэтгэдэг.

### III. Дүгнэлт

Цахар Гэвш Лувсанчүлтэм нь “Гал тахих зан үйл баясгалан гарахын орон”, “Гүүний сүүний цацлын ёсон” гэх зэрэг шүлэг магтаалаараа ард түмний шашны зан үйл, билэгдэлийн ахуй амьдралын бодит хэрэгцээ, хэрэглээний соёлд ойртуулж өгсөнөөрөө онцлогтой. Тиймээс ч Цахар Гэвшийн шүлэг, сургаал, магтаал, тайлбар тэргүүтэн олон зохиол нь зөвхөн сүм хийдийн

явцуу хүрээнд үлдсэнгүй, жирийн айл гэрт хүртэл түгэн тархаж нийтийн хүртээл болж чадсан. Түүний нэг тод жишээ бол “Баясгалангийн гарах орон хэмээх оршив” хэмээх судар юм. Цахар Гэвш Лувсанчүлтэмийн зохиосон «*Баясгалангийн гарах орон хэмээх оршив*» судар нь тухайн цаг үедээ нийгмийн чухал ач холбогдолтой байснаар барахгүй, XXI зуунд ч түүний үнэ цэнийг эрдэм шинжилгээний шинэ эргэлтэд оруулж, монголчуудын өнөөгийн гал тахих ёс, зан заншилын утга агуулгыг цаашид нягтлан судлахад ихээхэн ач тустай хэмээн дүгнэж байна.

### Ашигласан материал

Бира Ш. 1978. *Монгольская историография XIII-XVIII вв.* Москва.  
Цэрэнсодном Д. 1997. *Монголын бурханы шашны уран зохиол.* Улаанбаатар: Хэл зохиолын хүрээлэн, ШУА. .  
Хүрэлбаатар Л. 1997. *Монголын бурханы шашны уран зохиол.* Улаанбаатар: Хэл зохиолын хүрээлэн, ШУА.  
Философийн хүрээлэн, ШУА. 2001. *Монголын философийн түүх (XVII-XIX зуун).* Улаанбаатар .  
Сөөө З. 2012. *Монголчуудын эртний соёл ухамсрын арвин тайлбар.* Хөх хот , ӨМӨЗО: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.  
Давгадорж Д. 1995. *Монголын шашин суртахууны тайлбар толь.* Улаанбаатар: ФСЭХ, ШУА, Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо.

Оч Н. 2010. *Монголчуудын гал тахилгын судар оршвой.* Улаанбаатар: Өвөрмонголын хэвлэлийн хороо.  
Шагдарсүрэн Ц. 2003. *Монголчуудын утга соёлын товчоо.* Vol. II боть. Улаанбаатар.  
Гумилев Л.Н. 2000. *Хүн гүрэн. Тал нутгийн тухай гурвал .* Улаанбаатар.  
Шонхор А., Цэцэнбилэг. 2017. “Баясгалангийн гарах орон хэмээх оршив” судар. Хөх хот, ӨМӨЗО: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.  
Энх-Уянга Б. 2016. *Монголын уламжлалт ёс заншил тайлбар толь.* Улаанбаатар.